

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ

2017 ОНЫ 3 ДУГААР САРД

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-уудын нийтэд ил болгох ёстой мэдээллээс зургааг нь сонгон авч 2017 оны 3 дугаар сарын туршид эдгээр мэдээллийг хэрхэн ил тод болгож байгааг ажиглав. Энэхүү ажиглалтыг иргэний нийгмийн байгууллагууд хийж гүйцэтгэлээ.

## АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



3 дугаар сард нийт гурван дүүргийн ЗДТГ 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь нийтэлсэн нь өмнөх сартай харьцуулахад ахиц гараагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийслэл, дүүргүүдийн ЗДТГ 2017 оны 3 дугаар сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).

100.0%

Сүхбаатар дүүрэг, Багахангай дүүрэг, Хан-Уул дүүрэг

96.4%

Баянзүрх дүүрэг

94.7%

Чингэлтэй дүүрэг

86.7%

Баянгол дүүрэг

66.7%

Багануур дүүрэг, Налайх дүүрэг

46.7%

Сонгинохайрхан дүүрэг

33.3%

Нийслэл

Тайлбар: 1 🏠 = 10%

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН  
НИЙТЭЛСЭН ГҮЙЛГЭЭ БА ТҮҮНД ХАМААРАХ  
ШИЙДВЭРҮҮД



■ Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний тоо  
■ Холбогдох шийдвэрийн тоо

(Тайлбар 1-ийг үзнэ үү)

ХУДАЛДАН АВАЛТ БА ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд 2017 оны 3-р сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээгээ 4-р сарын 8-ны дотор бүгд нээлттэй мэдээлжээ.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу ил болгох 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг Сүхбаатар, Чингэлтэй, Налайх, Багахангай, Хан-Уул, Баянгол, Багануур, Сонгинохайрхан дүүргүүдийн ЗДТГ-ууд нийтэлжээ.
- Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийслэлийн хэмжээнд Налайх, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хугацаанд нь нийтэлсэн. Харин 2 дугаар сард Баянгол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцорч нийтэлсэн бол 3 дугаар сарын байдлаар бусад дүүргийн ЗДТГ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ил тод болгоогүй хэвээр байна.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт болон гүйлгээний тоог гаргахдаа ЗДТГ-ын шилэн дансанд нийтлэгдсэн мэдээллээс зөвхөн үүнд хамааралтайг түүвэрлэж авсан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 3 дугаар сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ  
– Шилэн дансны нэгдсэн цахим хуудас  
– ЗДТГ-ын цахим хуудас

– ЗДТГ-ын мэдээллийн самбар  
– Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас үзнэ үү.